



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №04

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2023 оны 01-р сарын 26 наас 02-р сарын 6 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2023 оны 01-р сарын 26 наас 02-р сарын 6 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N6, H5N1, H3N8, H7N9, H6N1, H10N8, H7N4, H5N8, H10N3 вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2023 оны 01-р сарын 26 наас 02-р сарын 6 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, Бельги, Боливи, Чили, КостаРика, Чех, Эквадор, Франц, Индониз, Япон, Молдав, Польш, Румин, Өмнөд Африк, Швед, АНУ, Вьетнам, Израйл зэрэг 19 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 106 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1-ээс харна уу). Хун, галуу, нугас, шонхор, цахлай, хэрээ зэрэг нүүдлийн усны, махчин 13 зүйлийн шувуудад өвчлөл бүртгэгдсэн.


Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	Австри	Гунгар хун, цахлай	26
H5N1	Бельги	Цахлай, сар шувуу	8
H5	Боливи	Тахиа шувууны аж ахуй	5
H5N1	Чили	Борцгор хотон	1
H5N1	КостаРика	Тахиа шувууны аж ахуй, хотон шувуу	3
H5N1	Чех	Тахиа шувууны аж ахуй, зэрлэг нугас, бор галуу	6
H5N1	Эквадор	Тахиа шувууны аж ахуй, цахлай	11
H5N1	Франц	Тахиа шувууны аж ахуй, хөх дэглий, бор галуу, гунгар хун	18
H5	Индониз	Тахиа шувууны аж ахуй	11
H5N1	Япон	Нугас, тахиа шувууны аж ахуй	4
H5N1	Молдав	Тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Польш	Хон хэрээ, гунгар хун	3

H5N1	Румин	Гангар хун, тахиа шувууны аж ахуй	4
H5N1	Өмнөд Африк	Тодорхойгүй	2
H5N1	Швед	Гангар хун, тахиа шувууны аж ахуй	2
H5N1	Швейцар	Хүрэн толгойт цахлай, гунгар хун	3
H5N1	Тайвань	Нугасны аж ахуй	14
H5N1	АНУ	Шунгуур, нугас, тахиа шувууны аж ахуй, цацагт хяруул, орог тогоруу, хотон	3
H5N1	Вьетнам	Нугас, тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Израйл	Тахиа шувууны аж ахуй	1
H5N1	Непал	Тахиа шувууны аж ахуй	1

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Зураг 1. 2023 оны 01-р сарын 26 наас 02-р сарын 6 ны хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт



Хөхтөн амьтад: А хүрээний H5N1 хэвшинжийн вирусээр Их Британи улсын Поуис мужид үнэг (1), голын халиу (4), Перу улсад далайн арслан (3), далайн гахай (1), Нидерланд улсад тус тус бүртгэгдсэн.

2021-2022 оны хугацаанд Нидерланд улсад Өндөр хоруу чанартай эмгэг төрүүлэгч шувууны томуугийн (HPAI) вирусийн дэд төрөл H5N1-ээр дэгдэлт үнэг *Vulpes vulpes*, суусар *Mustela putorius*, голын халиу *Lutra lutra* болон дорго *Meles meles* зэрэг махчин амьтадын дунд халдварласан байна. Мэдрэлийн системийн шинж тэмдэг илэрсэн учир ихэнх амьтдыг шинжилгээнд хамруулсан. Тус судалгаанд 11 амьтдыг хамруулж Өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 вирус болон PCR, иммуногистохимийн аргаар

шинжлэхэд зэрлэг махчин амьтадын их тархины бор гадаргын эд эсэд шинжилгээ хийхэд тархи нугасны үрэвслийн шинж тэмдэг илэрсэн байна. Амьсгалын замаас авсан сорьцоос халдвар илрэх нь бага байсан. Шинжилгээний дараа геномын дарааллыг тогтоох шинжилгээ хийсэн ба Нидерланд улсад зэрлэг шувуудын дунд бүртгэгдсэн өвчлөлтэй холбоотой болох нь харагдсан. Гэвч махчин амьтдын хооронд тодорхой холбоо хамаарал харагдаагүй тул эдгээр махчин амьтдын хооронд халдвар дамжсан гэж үзэхээргүй байна.

Ихэнх хөхтөн амьтдад вирусийн PB2-E627K мутац илэрдэг ба хувьсал нь хөхтөн амьтдын дунд явагдаж байгааг харуулж байна. Зэрлэг амьтдын тандалт судалгаагаар сорьц материал авахдаа амьтдын тархи нугаснаас авах шаардлагатай. Нэг эрүүл мэнд зорилтыг хангах зорилгоор зэрлэг амьтдын дунд тандалт судалгааг хийж, болзошгүй халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Эх сурвалж: [///D:/2023%20WORK/pathogens-12-00168-v2%20\(1\).pdf](///D:/2023%20WORK/pathogens-12-00168-v2%20(1).pdf)

Дөрөв. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувуугаар дамждаг бусад өвчлөлийн мэдээлэл:

Шувууны томуугийн Ньюкастли өвчний 1 тохиолдол Франц, Испани улсын хил хязгаарт буюу Баскийн газар нутагт бүртгэгдсэн. Шувууны үржүүлгийн аж ахуй нь 1600 орчим тагтаатай бөгөөд 200 орчим нь үхсэн байна. Тухайн орчинд хөл хорих, хязгаарлалт тогтоох, халдваргүйжүүлэлт зэрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. Энэхүү өвчлөл нь 2022 оны 9-р сараас хойш олон улсад нийт 9 тохиолдол Европ тивд (ОХУ, Швед, Франц) бүртгэгдсэн.

2023 оны 01 сарын 31 нд Швед улсын Лен Блекинге мужид дахин 1 нюкастли өвчний тохиолдол бүртгэгдэв. Өвчлөл бүртгэгдсэн 5000 тахиатай аж ахуйд 2023 оны 01 сарын 18 наас шувуудын дунд өндөгний тоо цөөрөх, хальс өөрчлөгдөх зэрэг шинж тэмдэг илэрч эхэлсэн байна. ОХУ-д 2022 оны 10-р сараас хойш нийт 6 тохиолдол бүртгэгдсэн. 2023 оны 02 сарын 1 нд тухайн өвчнөөр Хондурас улсын Атлантита боомт хотод 127 хотон шувуу үхсэн байна.

Эх сурвалж: <https://wattagnet.com/articles/46503-russia-dealing-with-newcastle/>

ЗӨСҮТ-Шувууны томуу хариуцсан баг